



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Шилэн дансны 2022 оны эхний 6 сарын гүйцэтгэлд хийсэн дотоод хяналт шалгалтын тайлан.

Аудитад хамаарах нэгжүүд: ИАлба, ЗУХэлтэс, СЭЗХэлтэс, ХААХэлтэс

Огноо: 2020 оны 06 сар 29

АУДИТЫН ХУГАЦАА:

Эхлэх хугацаа 2022.06.29

Дуусах хугацаа 2022.07.07

1. АУДИТЫН ЗОРИЛГО.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж дүгнэлт гарган холбогдох алба, хэлтэст зөвлөмж өгөх, дүнг ЭХЯаманд хүргүүлэх.

2. АУДИТЫН ЦАР ХҮРЭЭ.

ИАлба, ЗУХэлтэс, СЭЗХэлтэс, ХААХэлтэс.

3. АУДИТЫН ҮР ДҮН

- Шилэн дансанд холбогдох мэдээллийг “Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу үнэн зөв, иж бүрэн, тогтоосон хугацаанд байршуулан ажиллаж байгаа талаар

“Шилэн дансны тухай хууль”, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангах талаар Гүйцэтгэх захирлын 2020 оны 11 дүгээр сарын 18 өдрийн А/90 тоот тушаал гарсан ба уг тушаалаар цахим хуудсанд тавигдах мэдээлэл, шилэн самбарт мэдээлэл тавих ажилтнуудыг үүрэгжүүлсэн. 2022 оны 03-р сард ХАА-ны хэлтсээс оруулах байсан бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээнүүдээс бусад мэдээллийг шилэн дансанд цаг тухайд нь бүрэн оруулж ажилласан ба шилэн дансанд мэдээлэл байршуулсан байдалд сар бүр хяналт тавин ажиллаж байна. ХААХэлтсийн гэрээний мэргэжилтэн 4-р сарын мэдээллийг 5-р сард оруулахдаа андуурч 3-р сарыг сонгосноос төлөв өөрчлөгдөж хугацаа хоцорсон ангилалд шилжсэн. 3-р сард мэдээлэл сольж залруулга хийгээгүй бөгөөд ажил гүйцэтгэх үедээ алдаа гаргасан байна. 5, 6-р сарын гэрээний мэдээллийг хугацаанд нь мэдээлж өмнөх хоцроосон зөрчлөө арилгаж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллав.

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж 7 чиглэлүүдээр “Ил тод, мэдээлэл”-ийн самбарт сар бүр мэдээллээ шинэчлэн, байршуулж ажиллав.

- Шилэн дансны цахим хуудсанд тавигдсан мэдээллийг үнэн зөв гаргаж, иж бүрэн тайлагнасан эсэхэд дотоод аудитороос үнэлэлт өгч дараах зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл хариуцсан ажилтан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” хүлээн авч шилэн дансанд мэдээлэхдээ тендерийн нээлт хийсэн эсэхийг хянах.

Шилэн дансанд мэдээлэл оруулдаг ажилтнуудыг чадваржуулах.

- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд хяналт тавьсан талаар:

Шилэн дансны тухай хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу тавих хяналтыг тогтмолжуулж, хэрэгжилтийн талаар Гүйцэтгэх захиралд тайлагнаж, зөрчил гаргасан холбогдох албан тушаалтанд арга хэмжээ тооцон ажиллав.

Хянасан:

ДХХ-ийн дарга

М.Галхүү

Тайлан бичсэн:

Дотоод аудитор

С.Үнэнхүү